БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ

..... Т.ДАВААДАЛАЙ

ДЭНЖИЙН МЯНГА ДЭД ТӨВИЙГ ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМД ХОЛБОХ, ОРГИЛ АЧААЛЛЫН ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР БАРИХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 02 -р сарын 09-ны өдөр № Улаанбаатар хот

1.	Ерөнхий үндэслэл:	Улаанбаатар хотын Дэнжийн мянга орчмын гэр хороолол, дахин төлөвлөлтийн бүсийн дулааны ачаалал сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, төвлөрсөн дулаан хангамжийн системийн найдвартай ажиллагаанд ачаалал үүсгэж байна. Ялангуяа өвлийн оргил ачааллын үед дулааны дутагдал, даралтын уналт, дулаан тасалдал гарах эрсдэл өндөр байгаа тул оргил ачааллыг нөхөх зориулалттай, уян хатан ажиллагаатай дулааны эх үүсвэр барих шаардлага үүсээд байна. Мөн түүнчлэн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад бодит үр дүн үзүүлэх техник технологи байх шаардлагатай байна. - Засгийн газрын 2025 оны 33 дугаар тогтоол; - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 24/13 дугаар тогтоол; - Засгийн газрын 2025 оны 133 дугаартай агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол; - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/01 дугаартай төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай тогтоол;
2.	Байршил	- Чингэлтэй дүүрэг 10, 11, 12, 13-р хороо, Дэнжийн мянга дэд төв
3.	ТЭЗҮ боловсруулах ажлын зорилго	Дэнжийн мянга орчимд барих оргил ачааллын дулааны эх үүсвэрийн техник, технологийн оновчтой хувилбар, эдийн засгийн үр ашиг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг иж бүрэн судалж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үндэслэлийг бүрдүүлэхэд оршино.
4.	Ажлын зорилго	Дэнжийн мянга бүсэд барих оргил ачааллын дулааны эх үүсвэрийн: • Хүчин чадал, технологийн шийдлийг тодорхойлох • Техник, эдийн засгийн хувилбаруудыг харьцуулан үнэлэх • Хөрөнгө оруулалтын өртөг, ашиглалтын зардал, дулааны ѳѳрийн өртгийг тооцох • Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

		• Теслийг хэрэгжүүлэх оновчтой хувилбарыг санал болгох
5.	Судалгааны хамрах хүрээ	ТЭЗҮ боловсруулах ажил нь дараах үндсэн бүлгүүдийг хамаарна: Дулааны ачааллын судалгаа • Дэнжийн мянга орчмын одоогийн болон ирээдүйн дулааны хэрэглээний тооцоо • Оргил ачааллын хэмжээ (Гкал/цаг, МВт) • Дулаан хангамжийн одоогийн системийн үнэлгээ Технологийн хувилбаруудын судалгаа • Дараах технологиудыг (эсхүл шаардлагатай бусад хувилбаруудыг) судалж харьцуулна: • Хийн зуух/хий-түлшний уян хатан станц • LNG / LPG түлш ашиглах шийдэл • Бусад дэвшилтэт, нүүрс багатай технологи Байршил, дэд бүтцийн судалгаа • Газрын байршлын сонголт, инженер-геологийн нөхцөл • Дулааны шугам сүлжээтэй холбогдох боломж • Цахилгаан, ус, хий, авто замын хангамж Техникийн шийдэл • Үндсэн тоног төхөөрөмжийн сонголт • Дулааны схем, технологийн урсгал зураг • Автоматжуулалт, хяналтын систем • Найдвартай ажиллагаа, нөөцлөлт Эдийн засаг, санхүүгийн тооцоо • Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо (CAPEX) • Ашиглалт, засвар үйлчилгээний зардал (OPEX) • Дулааны өөрийн өртөг • Санхүүгийн үзүүлэлтүүд (NPV, IRR, Payback) • Тарифын нөлөөллийн үнэлгээ Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл • Агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлын үнэлгээ • Дуу чимээ, ус, хөрсний нөлөөлөл • Нийгэм, эрүүл мэндийн урьдчилсан үнэлгээ Эрсдэл, хэрэгжилтийн төлөвлөгөө • Теслийн эрсдэлийн шинжилгээ • Хэрэгжүүлэх үе шат, хугацаа • EPC, EPCM, эсхүл бусад хэрэгжилтийн загварын санал
6.	Эрсдэлийн үнэлгээ	• Эрсдэлийн үнэлгээг өнөөгийн болон ирээдүйн нөхцөл байдалд тулгуурлан үнэн зөв хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг гаргах. • Теслийн орлого болон зардлын эрсдэлийг тодорхойлох, холбогдох мэдрэмжийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ боловсруулах
7.	Боловсон хүчин	• Мэргэжилтэй ажиллах хүч бэлдэх шаардлагатай сургалт, дадлагажуулалт зохион байгуулах арга хэмжээг төлөвлөх

8.	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	• Дулаан, эрчим хүчний салбарт ТЭЗҮ боловсруулсан туршлагатай байх • Мэргэшсэн инженер, эдийн засагч, байгаль орчны мэргэжилтнээс бүрдсэн багтай байх • Монгол Улсын холбогдох хууль, стандарт, норм дүрмийг баримтлах
9.	Ажлын хугацаа	ТЭЗҮ боловсруулах ажлыг гэрээ байгуулснаас хойш 100 хоногийн дотор гүйцэтгэнэ. Үүнд: • Эхлэлийн тайлан: /30 хоногт гүйцэтгэнэ / • Дундын тайлан: /20 хоногт гүйцэтгэнэ/ • Эцсийн тайлан: /20 хоногт гүйцэтгэнэ/ • Магадлалын ажил: /30 хоногт гүйцэтгэнэ/
10.	Дүгнэлт, санал боловсруулалт	Тооцоо, үнэлгээний үр дүнгүүдэд тулгуурлан төслийг хэрэгжүүлэх оновчтой хувилбарыг томъёолохын зэрэгцээ уг төслийн хэрэгжүүлэхэд гарч болзошгүй хүндрэл, эрсдэлүүдийг зөв тодорхойлж, тэдгээрийг арилгах, хөнгөвчлөх арга замуудыг болон оновчтой хувилбарыг зөвлөмж болгох.
11.	Гарах үр дүн	Гүйцэтгэгч нь дараах баримт бичгийг хүлээлгэн өгнө: • ТЭЗҮ тайлан 3 хувь (Монгол хэлээр, шаардлагатай тохиолдолд Англи товч хураангуйтай) • Станцын ерөнхий төлөвлөлтийн зураг, байршлын зураг, техникийн схем зураг • Санхүү, эдийн засгийн шинжилгээ • Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ • ТЭЗҮ боловсруулах, сонголт хийхэд ашигласан бусад тооцоо судалгаа, хувилбар • Дижитал файл (PDF, Word, Excel)
12.	Баталгаажуулалт	Техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

ХЯНАСАН:

НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР ОНӨТҮГ-ЫН ЗАХИРАЛ Э.ТҮВШИНЖАРГАЛ

ТӨСӨЛ ДЭМЖИХ МЕНЕЖМЕНТИЙН АЛБАНЫ ДАРГА /АХЛАХ МЕНЕЖЕР/ Б.МӨНХБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРЧИМ ХҮЧ ХӨГЖҮҮЛЭЛТ ТӨСЛИЙН АХЛАХ ИНЖЕНЕР С.МӨНХБАТ

ТӨСЛИЙН ИНЖЕНЕР А.ОТГОНБААТАР